



ДУНДГОВЬ АЙМАГ  
ГОВЬ-УГТААЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 01 сарын 04 өдөр

Дугаар А/01

Хажуу шинэ ус

Бүх нийтийн боловсролыг дэмжих жил  
болгон зарлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29.2 Сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн 1.3.3.6, 1.3.3.8, 1.4.1.3, 1.4.2.1, 1.4.2.2, 1.5.1.2 заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Орон нутгийн хэмжээнд Сургууль Цэцэрлэгийн сургалтын чанарыг сайжруулах, багш ажилчдын заах арга зүйн чадварыг нэмэгдүүлэх, иргэдийн боловсролын түвшинг ахиулах, мэдлэг боловсрол олгох, соён гэгээрүүлэх, жижиг дунд үйлдвэрлэл эрхлэх арга зүйгээр хангах зорилгоор 2022 оныг бүх нийтийн боловсролыг дэмжих жил болгон зарласугай.

2.Бүх нийтийн боловсролыг дэмжих жилийн ажлын төлөвлөгөөг иргэд, албан хаагчдын санал хүсэлд тулгуурлан боловсруулж батлуулан удирдлага зохион байгуулалтаар хангаж биелэлт үр дүнг тооцож ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Н.Өлзийтогтох), төлөвлөсөн ажлуудыг үр дүнтэй зохион байгуулж ажиллахыг албан байгууллагын дарга, эрхлэгч нарт үүрэг болгосугай.

3.Төлөвлөсөн арга хэмжээнүүдэд шаардагдах санхүүгийн зардлыг уул уурхай, аж ахуй нэгж байгууллага, иргэд, малчдын хандив, дэмжлэг, төсөл хөтөлбөрөөр санхүүжүүлж ажиллахыг байгууллагуудын дарга, эрхлэгч нарт зөвшөөрсүгэй.

4.Сурч боловсрох, оюун санаагаа хөгжүүлэхэд санаачлага гарган эрдэм мэдлэгээ ахиулж ажил амьдралд үр дүн гарган ажиллахыг нийт иргэдэд уриалсугай.

ЗАСАГ ДАРГА



Ө.МӨНХ-АМГАЛАН